

Захирлын 2022 оны 04 дүгээр сарын 07-ны
өдрийн 70 тоот тушаалын нэгдүгээр хавсралт

**ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛЬД
ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**



/2022-2023 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛ/

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Техник технологийн дээд сургууль /ТТДС/-д оюутан элсүүлэхдээ "Боловсролын тухай" хууль, "Дээд боловсролын тухай" хууль, БШУ-ны сайдын 2013 оны А/79 тоот тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", /БСШУ-ны сайдын 2016 оны 03 сарын 16-ны өдрийн А/87 тоот тушаал, БСШУС-ын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/194 тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/, БСШУС-ын сайдын 2021 оны 05-р сарын 20-ны өдрийн А/187 тоот тушаал болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. Элсэн суралцахаар хүсэлт гаргагч, тэдний хэрэгцээ, хүсэл сонирхолд үндэслэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн элсэлтийн ажлыг зохион байгуулах элсэлтийн комиссын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.3. Оюутан элсүүлэх ажлыг сургуулийн удирдах зөвлөлөөс тогтоосон хөтөлбөр /мэргэжил/, хяналтын тоог баримтлан зохион байгуулна.
- 1.4. ТТДС-д оюутан элсүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэргэжил сонголт хийлгэх үйл явц ил тод, шударга, хүртээмжтэй байна.

ХОЁР. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ

2.1 Элсэгчдэд тавигдах шаардлага

- 2.1.1 Элсэгч нь суралцах мэргэжлээ сонгосон, тухайн чиглэлээр суралцах сонирхол, авьяас, бэлтгэлтэй, бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой байна.
- 2.1.2 Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгч нь монгол хэл, бичгийн шалгалт болон ерөнхий боловсролын түвшин, мэдлэг, чадварыг тогтоох зорилго бүхий элсэлтийн ерөнхий шалгалт /ЭЕШ/ өгч, энэ журмын хавсралтад заасан хөтөлбөрт хамаарах 2-оос доошгүй хичээлээр ерөнхий шалгалтад тавигдах босго онооны болзлыг хангасан байна.
- 2.1.3 Элсэлтийн ерөнхий шалгалт болон монгол хэл, бичгийн шалгалтын босго оноог тухайн үед үндэсний хэмжээнд тогтоосон босго оноогоор тооцно. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүнгийн тухай баримт бичиг түүнийг олгосон өдрөөс хойш 2 жил 6 сарын хугацаанд хүчинтэй байна.
- 2.1.4 Элсэлтийн ерөнхий шалгалт өгч ТТДС-д элсэх болзول хангасан элсэгч өөрийн суралцах бэлтгэл, авьяас чадвар, туршилага, хувийн зан чанар хэрхэн суралцаахаа илэрхийлсэн эсээ бичиж элсэлтийн комисст ирүүлнэ.
- 2.1.5 Иргэнийг дараах тохиолдолд элсэлтийн ерөнхий шалгалтгүй элсүүлэн суралцуулна. Үүнд:
 - 2.1.5.1 Дээд боловсролтой иргэн хоёр дахь дээд боловсрол эзэмших
 - 2.1.5.2 Дипломын боловсролтой, Тусгай мэргэжлийн дунд сургуулийг төгссөн иргэн мэргэжлийн дагуу бакалаврын хөтөлбөрт элсэх суралцааг
 - 2.1.5.3 Хөрвөх сургалтад хамрагдах суралцааг

- 2.1.5.4 Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн, улс орнуудад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж, дүйцүүлсэн батламж авсан иргэн
- 2.1.5.5 Гадаад улсаас ижил түвшний дээд боловсролын сургалтын байгууллагад шилжин суралцах
- 2.1.6 Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгч ерөнхий чиглэлээр суралцсаны дараа суралцсан хугацааны дүнгээр жагсан тухайн багцын хөтөлбөрүүдээс мэргэжлийн сонголт хийж үргэлжүүлэн суралцаж төгсөнө.
- 2.1.7 Бакалаврын болон магистрын хөтөлбөрт элсэгч нь энэхүү журмын 3.1-д заасан материалыг бүрдүүлж элсэнэ.
- 2.1.8 2.1.5-д заасан элсэгчийн бичиг баримтыг үндэслэн багц цагийг бүрэн судалсан элсэгчийн судалсан кредитийг "Кредит дүйцүүлэх журам"-аар зохицуулна. Энэ тохиолдолд зарим тодорхой мэргэжлүүдээр сургуулийн зүгээс элсүүлэх тоонд хязгаарлалт тавьж болно.

2.2 Элсэлтийн бүртгэл

- 2.2.1 Элсэлтийн бүртгэлийг сургуулийн www.iet.edu.mn/elselt - элсэлтийн вэб хуудсаар дамжуулан хийх бөгөөд элсэхийг хүсэгч өөрийн биеэр хичээлийн байранд ирж бүртгүүлж болно.
- 2.2.2 Элсэхийг хүсэгч нь элсэлтийн вэб хуудсанд нэвтэрч, шаардлагатай мэдээллийг үнэн зөв оруулан, бүртгэлийн хураамжийг төлж баталгаажуулна.
- 2.2.3 Бүртгэл 2022 оны 04-р сарын 2-ны өдрөөс эхэнлэ.
- 2.2.4 Элсэлтийн үйл ажиллагаа тус сургуулийн элсэлтийн хяналтын тоо дууссан тохиолдолд дуусгавар болно.
- 2.2.5 Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг элсүүлэхдээ "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль"-ийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг үндэслэн элсэгчийн үнэмлэх, шийдвэрийг зохих баримт бичгийн бүрдэлд оруулна.

2.3 Элсэлтийн онооны эрэмбэлэлт, баталгаажуулалт

- 2.3.1 Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэгчдээс ерөнхий шалгалтын босго давсан оноогоор хөтөлбөр бүрээр жагсаан хяналтын тоог баримтлан элсүүлнэ. /Хавсралт-1/
- 2.3.2 Архитектурын мэргэжлээр элсэгчдээс хугацаа зарлан хар зургийн ур чадварын түвшин тогтоох нэмэлт шалгалтыг ТТДС -ийн хичээлийн байранд авч ерөнхий шалгалт, нэмэлт шалгалтын онооны дунджаар жагсаан элсүүлнэ.
- 2.3.3 Элсэх болзол хангаж хяналтын тоонд багтсан хүмүүст хариуг тухай бүрт цахим хаягаар болон сургуулийн вэб хуудсаар мэдэгдэж, суралцах эрхийн бичиг олгоно.
- 2.3.4 Бүртгэлийн хугацаанд бүртгэлээ цуцлах, бүртгэл дууссаны дараа өөр сургууль сонгох, зэрэг элсэх боломжгүй болсон тохиолдолд элсэлтийн хураамжийг буцаан олгохгүй бөгөөд шилжүүлэн тооцохгүй.
- 2.3.5 Элсэгч нь тэнцсэн тухай мэдээллээ авч, суралцах эрхийн бичгээ авснаар сургалтын гэрээг сургуулийн оюутан төгсөгчдийн албатай байгуулна.

ГУРАВ. СУРАЛЦАХ ГЭРЭЭ

- 3.1. Суралцах эрхийн бичиг авсан элсэгч 2022 оны 08-р сарын 23-30 -ны өдрүүдэд бичиг баримтын бүрдүүлэлт хийж сургуулийн оюутан төгсөгчдийн албандаа өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Элсэгч дараах материалыг бүрдүүлнэ. Үүнд:

Бакалаврын өдрийн хөтөлбөр	Бакалаврын эчнээс, Магистрын хөтөлбөр
1. Тусгай загварын өргөдөл	1. Тусгай загварын өргөдөл <small>ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГАЛТЫН ХУУЛБАР</small>
2. Боловсролын гэрчилгээ, диплом	2. Бакалаврын диплом
3. Хувийн хэрэг	3. Өөрийн иргэний үнэмлэхний хуулбар
4. Ерөнхий шалгалтын батламж, монгол хэл бичгийн шалгалтын батламж	4. 3x4 хэмжээтэй тухайн оны фото зураг /4%/
5. Өөрийн болон эцэг, эхийн иргэний үнэмлэхний хуулбар	5. Ажил эрхэлдэг бол ажлын газрын тодорхойлолт
6. 3x4 хэмжээтэй тухайн оны фото зураг /4%/	6. Элсэгчийн эсээ / Суралцах төлөвлөгөө /
7. Элсэгчийн эсээ / Суралцах төлөвлөгөө /	

- 3.2. Элсэлтийн үед бүрдүүлэх материалыг хурамчаар бүрдүүлсэн, материал бүрдэлт дутуу зэргээс холбогдон гарах хариуцлагыг бүртгүүлэгч өөрөө хүлээнэ.
- 3.3. Элсэгч нь мэргэжлээ сонгож бүртгүүлсний дараа сургалтын гэрээ байгуулж сургалтын төлбөрөө төлснөөр суралцах эрхээр хангагдана.
- 3.4. Дээр дурьдсан хугацаанд ирээгүй, хүндэтгэх шалтгаанаа урьдчилан мэдэгдээгүй элсэгчдийг гэрээ байгуулахаас татгалзсан гэж үзэж элсэх эрхийг хүчингүй болсонд тооцно.
- 3.5. Элсэлттэй холбоотой мэдээллийг цахим сан бүрдүүлэн архивлана.
- 3.6. Суралцагч элсүүлэхдээ хандив, энэхүү журамд зааснаас бусад төлбөр, хураамж авахыг хориглоно. Журмыг зөрчсөн багш, ажилтанд хариуцлага тооцно.

ДӨРӨВ. БИЧИГ БАРИМТ БУЦААН ОЛГОЛТ, ХАРИУЦЛАГА

- 4.1 Сургуультай холбоогүй болсон бүртгүүлэгчид 8 сарын 26-наас 10-р сарын 1-ний дотор бичиг баримтаяа буцаан авч болно.
- 4.2 Элсэн суралцаагүй бүртгүүлэгчдийн бичиг баримтыг оюутан төгсөгчдийн алба сургуулийн архивт 2022 оны 10 сарын 15-ны дотор шилжүүлнэ.
- 4.3 Элсэгч нь суралцах эрхийн бичиг хүчингүй болгосон тохиолдолд 1 кредиттэй тэнцэх үйлчилгээний төлбөр төлнө.

ТАВ. ЭЛСЭГЧДЭД ОЛГОХ СУРГАЛТЫН ТӨЛБӨРИЙН ХӨНГӨЛӨЛТ, ТЭТГЭЛЭГ

- 5.1 Элсэгчдэд сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлгийг дараах хэлбэрээр олгох ба давхцуулж олгохгүй. Давхсан тохиолдолд элсэг аль нэгийг өөрөө сонгоно.

№	Нэхцэл, шаардлага	Хөнгөлөлт, тэтгэлэг
		Авьяас чадварыг дэмжих тэтгэлэг
1	ЭЕШ-д журамд заасан 1 хичээлээр 600-аас дээш оноо авсан бол	800 бол 100% 751-799 бол 90% 701-750 бол 80% 681-700 бол 70% 651-680 бол 60% 600-650 бол 50%
2	Суралцах мэргэжлийн чиглэлийн дагуу олон улс, үндэсний, бүсийн болон ТТДС-ийн нэрэмжит олимпиад, уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 50% 2-р байр 40% 3 болон тусгай байр 30% Оролцсон-20%

3	Гадаад хэлний чиглэлээр олон улс, үндэсний, бүсийн уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 30% 2-3-р байр болон тусгай байр 20% Оролцсон-10% ТЕХНОЛОГИЙН
4	Урлаг, спортын чиглэлээр олон улсын болон улс, бүсийн уралдаан, тэмцээнд оролцсон бол	1-р байр 20% ДЭЭД СУРГУУЛЬСЫН 2-3-р байр болон тусгай байр 15% Оролцсон-10% ХТААЗЫН УЛААНБААТАР ХСҮ
5	Монгол улсын Засгийн газрын 46 дугаар тогтоолын дагуу дараах тэтгэлэг, хөнгөлөлтэд хамрагдах боломжтой. Үүнд: <ul style="list-style-type: none"> Шинэ элсэгч тухайн онд ЭЕШ-аа 600-аас дээш өгсөн нөхцөлд Боловсролын зээлийн сангийн "Оюутны хөгжлийн зээл"-д хамрагдах Элсэн суралцагч нь дээрх тогтоолын 5.1.2 заалтын дагуу голч дун нь 2,8 болон түүнээс дээш оноотой суралцаж Боловсролын зээлийн сангийн "Оюутны хөгжлийн зээл"-д хамрагдах 	
Нийгмийн байдлыг харгалзан сургалтын төлбөрийн хөнгөлөлт		
6	Нэг айлын 2-с дээш хүүхэд зэрэг суралцвал	2 бол аль нэг нь 30%, 3 бол аль нэг нь 50% /тус сургуульд нэгэн зэрэг сурдаг/
7	Улаанбаатар хотоос 500 км-ээс зайдай хөдөө орон нутгаас элсвэл	10%
8	Бакалаврын хөтөлбөрийн онцлох мэргэжлээр эмэгтэй хүүхэд элсэн суралцвал	10%
9	Хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин элсэгчдийг ЗГ-ын буцалтгүй тусламжид хамрагдах боломжтой.	
Хамтын ажиллагааг дэмжих, харьяа сургуулийн ажилтан болон ажилтны хүүхдэд дэмжлэг үзүүлэх, үнэнч үйлчлүүлэгчийг урамшуулах хөнгөлөлт		
10	Хамтын ажиллагааны гэрээтэй аж ахуйн нэгж, байгууллагаас 5 буюу түүнээс дээш ажилтан зэрэг элсвэл	тус бүр 10%
11	Сургуулийн төгсөгч шатлан суралцвал /тухайн жилдээ/	20%
12	ТТДС-ийн харьяа сургуулийн ажилтны хүүхэд болон өөрөө элсэн суралцвал	25%

5.2 Оюутан төгсөгчдийн албаны хариуцсан мэргэжилтэн элсэгчийн хөнгөлөлт, тэтгэлгийг нотлох баримтад үндэслэн захирлын тушаалаар баталгаажуулан элсэн орсон дараагийн улирлын эцэст шийдвэрлэнэ. Суралцагч нь сургалтын төлбөрийн 50 хувиас багагүй төлсөн байна.

5.3 Дээрх хөнгөлөлт, тэтгэлэг тухайн хичээлийн жилд хүчинтэй байх ба жилийн чөлөө авсан тохиолдолд дараа жилд шилжүүлэн тооцохгүй.

ЗУРГАА . СУРГАЛТЫН ТӨЛБӨР, ТӨЛӨХ ЗАРЧИМ

6.1 Тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хэмжээг сургуулийн Удирдах зөвлөл тогтооно.

6.2 Сургалтын төлбөр, түүнийг төлөх зарчмыг "Сургалтын гэрээ"-гээр зохицуулна

Захирлын 2021 оны 04 дүгээр сарын 07-ны
өдрийн 70 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

**Техник технологийн дээд сургуульд оюутан элсүүлэх хөтөлбөр /мэргэжил/-ийн
чиглэл**

№	Элсүүлэх хөтөлбөрийн нэр	Мэргэжлийн чиглэл	Боловсролын зэрэг, сургалтын хэлбэр	Элсэгчдийн боловсролын түвшин	Суралцах хугацаа	Ерөнхий шалгалтын босго оноо тооцох хичээл		
						Хичээл нэг	Хичээл хоёр	
1	Хүнсний инженерчлэл	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	Бакалавр, Өдөр	Бүрэн дунд, мэргэжлийн боловсрол түүнээс дээш	4 жил	1-р хичээл Хими, Биологи /Үндэсний хэмжээнд тогтоосон босго оноо/	Матемтик, Физик, Нийгмийн ухааны мэдлэг, Англи хэл, Хими, Биологи /Үндэсний хэмжээнд тогтоосон босго оноо/	
2	Барилгын инженер	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер	Бакалавр, Өдөр		4 жил	1-р хичээл Математик, Физик /Үндэсний хэмжээнд тогтоосон босго оноо/		
3		Сантехник инженерийн байгууламж	Бакалавр, Өдөр		4 жил			
4		Барилгын материал үйлдвэрлэлийн технологи	Бакалавр, Өдөр		4 жил			
5	Авто замын барилга	Авто замын барилга	Бакалавр, Өдөр		4 жил			
6	Гүүрийн барилга	Гүүрийн барилга	Бакалавр, Өдөр		4 жил			
7	Архитектур	Архитектур	Бакалавр, Өдөр		4 жил	1-р хичээл Математик, Ур чадвар /хар зураг/		
8	Хүрээлэн буй орчны инженер	Ус хангамж, ус цэвэрлэгээ	Бакалавр, Өдөр		4 жил	1-р хичээл Математик, Физик /Үндэсний хэмжээнд тогтоосон босго оноо/		
9	Авто инженер	Авто машин ашиглалт, авто аж ахуй	Бакалавр, Өдөр		4 жил			
10	Цахилгаан хангамж	Цахилгаан хангамж	Бакалавр, Өдөр		4 жил			
11	Цахилгааны инженер	Цахилгааны инженер	Бакалавр, Өдөр		4 жил			
12		Уул уурхайн тоног төхөөрөмжийн ашиглалт	Бакалавр, Өдөр		4 жил			
13	Компьютерын ухаан	Компьютерын ухаан	Бакалавр, Өдөр		4 жил	1-р хичээл Хими, нийгмийн ухааны мэдлэг /Үндэсний хэмжээнд тогтоосон босго оноо/		
14	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал	Бакалавр, Өдөр		4 жил			

15	Барилгын инженер	Сантехникийн инженерийн байгууламж	Бакалавр, Эчнээ	Диплом түүнээс дээш	2.5 жил	ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ДЭЭЛ СҮРГҮҮЛЭЛ
16		Иргэний ба үйлдвэрлэлийн барилгын инженер	Бакалавр, Эчнээ		2.5 жил	ХХК №019100052 Ф. №0389373 АТУ4208 УЛАНБАТАР ХОТ
17	Авто замын барилгын инженер	Авто замын барилгын инженер	Бакалавр, Эчнээ		2.5 жил	- -
18	Хүрээлэн буй орчны инженер	Ус хангамж, ус цэвэрлэгээ	Бакалавр, Эчнээ		2.5 жил	- -
19	Барилгын инженер		Магистр, едөр	Бакалаврын диплом	-	- -
20	Авто зам, Авто замын барилга		Магистр, едөр		-	- -
21	Барилгын материал үйлдвэрлэлийн технологи		Магистр, едөр		-	- -
22	Хөрсний механик ба буурь суурь		Магистр, едөр		-	- -
23	Гүүрийн барилга		Магистр, едөр		-	- -
24	Багш, мэргэжлийн боловсрол сургалт		Магистр, едөр		-	- -